



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/10

Жаргалант

2025 оны ойгоос бэлтгэх модны дээд
хязгаарыг батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар 18.2.7 дахь заалт, Хэнтий аймгийн Норовлин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Норовлин сумын ойн сангаас 2025 онд аж ахуйн нэгж, байгууллагын цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэх модны дээд хязгаар, ойжуулалтын ажлын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ойн нөхөрлөлүүд, багийн иргэдийн цэвэрлэгээний ажлаар бэлтгэх модны дээд хязгаар, ойжуулалтын ажлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Цэвэрлэгээний огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн аж ахуй нэгж бэлтгэсэн модны 100м³ тутамд 1 га-д, ойн цэвэрлэгээний ажлаар ойгоос мод бэлтгэсэн нөхөрлөл, байгууллага бэлтгэсэн модныхоо 100м³ тутамд 0,5 га-д, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор нас гүйцсэн ургаа нойтон мод ойгоос бэлтгэсэн иргэн огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тооны тарьц суулгацыг өөрийн хөрөнгөөр ойд тарьж ойжуулалт хийж ургуулах, түүнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

3.Мод бэлтгэлийн ажлын гүйцэтгэлд өдөр тутмын хяналт тавьж эхлэл, дуусгаврын актаар хөтлөх, мод тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллах, ойжуулах ажлыг зохион байгуулах, ойгоос мод бэлтгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, заавар, журмын дагуу гүйцэтгүүлж хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Д.Батбаяр), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Баярмагнай)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501019



Норовлин сумын Засаг даргын
2025 оны 01 дугаар сарын 08-ны өдрийн
А/0 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

д/д	Нөхөрлөл, ААНБ-ын нэр	Цэвэрлэгээний ажил.								Нийт дүн	Ойжуулах талбай, га	Уламжлалт бүтээгдэхүүн									
		Хэрэглээ, шоометр				Түлээ, шоометр						Хэрэглээ, шоометр					Түлээ, шоометр				
		шинэс	нарс	улиас	дүн	шинэс	нарс	улиас	бургас			хус	дүн	шинэс	нарс	улиас	дүн	шинэс	нарс	хус	бургас
1	Нарс		40		40		20		20		60	0,3									
2	Нуруу-Нарс		40		40		20		20		60	0,3									
3	Хөндлөн		40		40		20		20		60	0,3									
4	Баян	50			50	50			50		100	0,5									
5	Хан-Уул	50			50	50			50		100	0,5									
6	Хамтын хүч		40				20		20		60	0,3									
5	1-р баг	100	100		200	100	30		330		330	-				10	10				
6	2-р баг	100	100		200	100	30		330		330	-				10	10				
7	3-р баг	100	40		140	100	30		270		270	-				10	10				
8	4-р баг	100	100		200	200	30		430		430	-				10	10				
	Нийт дүн										1800	2,2				40	40	10		90	

2025 онд Ойн нөхөрлөлүүд болон багийн иргэдийн ойгоос бэлтгэх модны хуваарь /шоометр/

Тайлбар: Цэвэрлэгээний ажлаар мод бэлтгэсэн нөхөрлөлүүд хэрэглээний модны 100 м³ тутамд

0,5 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийнэ.



Норовлин сумын Засаг даргын
2025 оны 01 дугаар сарын 08-ны өдрийн
А/12.. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Цэвэрлэгээний огтлолт											
д/д	ААНБайгууллагын нэр	Хэрэглээ, шоометр				Түлээ, шоометр					
		шинэс	нарс	улиас	бурас	ДҮН	шинэс	нарс	улиангар	бурас	улиас
1	Сэвэлтийн булаг	100	20			120	200				200
	Нийт дүн	100	20			120	200				200
		НИЙТ ДҮН				Ойжуулалт /га/					
						3,2					

2025 онд аж ахуйн нэгж, байгууллагын ойгоос бэлтгэх модны дээд хязгаар, ойжуулалтын хуваарь

Тайлбар: Цэвэрлэгээний огтлолтоор мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын бэлтгэсэн хэрэглээний модны 100м³ тутамд 1.0 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийнэ.